



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 491

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд
төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй
гишүүдийг чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Амарзаяа, Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Буяннэмэх нарыг “Архангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компани, “Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компани, “Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

3.МЭНДСАЙХАН

А.АРИУНБОЛД



0000993

D:\Huraldaanii material\2019 он\2019.11.29 №23.docx